

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

**110/35/10 кВ Бэрх дэд станцад 110 кВ-ын
Цэнэг шавхагч нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон
шалгаруулах**

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: ХА№20/26

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“БЗӨБЦТС” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчоос ХАН№20/26 дугаартай 110/35/10кВ-н Бэрх дэд станцад 110кВ-н цэнэг шавхагч нийлүүлэх ажлын материалд үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналын нээлтийг 2020 оны 03 сарын 23-ны өдрийн 09 цаг 30 минутанд www.tender.gov.mn цахим хаягаар нээнэ.

Тендертэй холбоотой бусад мэдээллийг supply@bnedo.mn хаягаар авч болно.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Утас: 99105839

Факс: 70210167

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, цахим системээр нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон ийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Техникийн тодорхойлолт.
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материал. /ТШӨХ-ийн ТООЗ 1.1-д заасны дагуу/
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Маягтын дагуу үнийн санал ирүүлнэ. 2. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. /НӨАТ төлөгч биш бол энэ тухай албан бичиг ирүүлнэ/ 3. 2019 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг дүгнэлтийн хамт ирүүлнэ. 4. 2018-2019 онуудын борлуулалтын орлогын дундаж нь тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дахь заалтын дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэнэ/. 5. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолт, фото зургийг ирүүлнэ. 6. Гэрээний тусгай нөхцлийн 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. 7. Баталгаат засварын хугацааг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. 8. Бараа материал нийлүүлэх хугацаа ажлын 20 хоногоос ихгүй байна. 9. Сүүлийн 2 жилийн /2018, 2019/ хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, гэрээ, гэрээ дүгнэсэн актыг ирүүлнэ. 10. Гэрээний үүргээ бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ. /Захиалагчийн тодорхойлолт ирүүлээгүй тохиолдолд гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байсан гэж үзэн уг тендерээс татгалзана./
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Тендер хүлээн авах этгээд: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа: Огноо: 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Цаг: 09 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх хугацаа нь: Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Цаг: 09 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлалгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тухайн аж ахуйн нэгж шүүхийн ямар нэгэн маргаанд хариуцагчаар оролцож байгаагүй тухай шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт. 2. ШШГЕГ-ын шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт. /Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байх/ 3. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх. /Татварын тодорхойлолтыг www.tender.gov.mn цахим сайтын лавлагааг үндэслэнэ/ 4. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалтын шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p>

Дөрөв. БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Техникийн үзүүлэлт тайлбар
1	110кВ Цэнэг шавхагч / Y10W-126 дүйцэхүйц, тоолуур, зориулалтын төмөр хөл, бэхэлгээний төмөр хийцийн хамт/	ш	3	Техникийн тодорхойлолтын дагуу

110 кВ-Н ХЭТ ХҮЧДЭЛ ХЯЗГААРЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

А. Ашиглалтын нөхцлийн шаардлага

1. Суурилуулалтын нөхцөл: Гадаа
2. Суурилуулах өндөр: далайн түвшнээс дээш 1000 м
3. Орчны температур: -45°C - +45°C
4. Газар хөдлөлтийн зэрэг: 7-8 балл
5. Бохирдлын зэрэг : IY
6. Тусгаарлагын хийц: Шаазан
7. Салхины хурд: >35 м/сек
8. Харьцангуй чийгшил: ≥80%
9. Мөсжилтийн зэрэг : 10 мм
10. Зориулалт: Дэд станцын тоног төхөөрөмжийг хамгаалах


Б. Техникийн тодорхойлолт

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Техникийн өгөгдөл	
1	Хэвийн хүчдэл	кВ	110	
2	Ажлын хамгийн их хүчдэл-Us	кВ	126	
3	Ажлын үргэлжилсэн хүчдэл- Us	кВ	96	
4	Хэвийн цэнэгжилтийн гүйдэл	кА	10	
5	Хэвийн 4/10 мкс импульсын их гүйдэл тэсвэрлэх чадвар	кА	100	
6	Системийн богино залгааны гүйдлийн хамгийн их утга	кА	40	
7	Хэвийн давтамж	гц	50	
8	2 мсек-ын гүйдлийн импульс тэсвэрлэх чадвар	А	≥850	
9	Гадаргуугаар гүйдэл нэвчих зай	мм	≥3986	
10	Хэсэгчилсэн цахилалтын зэрэг	pC	10	
11	Гадна эх биеийн тусгаарлага	Үйлдвэрлэлийн давтамжтай тэсвэрлэх хүчдэл	кВ	275
12		Аяндын импульсын тэсвэрлэх хүчдэл	кВ	650

Стандартууд : IEC 60099-5 , IEC 62271, IEC 60099-4 шаардлага хангасан байх

Нэмэлт шаардалага: 110 кВ-ын хэт хүчдэл хягаарлагчийн иж бүрдэл нь зориулалтын (гангийн орц бүхий) төмөр хийц, хөл, суурийн хамт байна. Төмөр хийцүүдийг үйлдвэрт зэврэлтээс хамгаалсан цайр (цинкээр) ISO1461:2009 стандартын дагуу халууны аргаар будсан байна. Үйлдвэрийн туршилт хийсэн бичиг баримт, сертификат, ашиглалт, засвар үйлчилгээний талаар танилцуулга, (Англи, Орос) хэлээр бичсэн гарын авлагатай байна.

1. Барааны тодорхойлолт: Y10W-126 дүйцэхүйц
2. Стандарт: IEC 60099-5 , IEC 62271, IEC 60099-4 шаардлага хангасан байна.
3. Бараа хүргэх газар: Багануур дүүрэг 3-р хороо Үйлдвэр хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК агуулах
4. Нийлүүлэх барааны ажлын болон фото зураг.



БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
ХА№20/26	110кВ Цэнэг шавхагч /тоолуур тай/	3	ширхэг	БЗӨБЦТС-ТӨХК агуулах	10	20	

ТАВ. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2020 оны дугаар сарын-ны өдөр

БЗӨБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 /нэг/ жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 2020 оны 2 дугаар улиралд багтаан хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. Захиалагч бараа материалыг ажлын хэсэг томилон шалгаж үзнэ. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн бараа материалыг хүлээн авна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) Нийлүүлэх барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Баталгаат засварын хугацаа **1 /нэг/** жил байна. Баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг талуудын төлөөлөгчид хамтран шалгаж актаар баталгаажуулах бөгөөд барааг нийлүүлэгч хуанлийн 10 хоногийн дотор өөрийн зардлаар сольж өгнө
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Үүнд: Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн 2020 оны 2 дугаар улиралд багтаан хийнэ.